



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/06

Жаргалант

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.9 дэх заалтыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хэнтий аймгийн Норовлин сумын харъяат Монгол Улсын “Биеийн тамирын тэргүүний ажилтан”, бөхийн чөлөөт барилдааны спортын мастер, сумын заан Түмэннастын Буянбат агсны нэрэмжит 2026 оны чөлөөт бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2026 оны 01 дүгээр сарын 30-аас 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд тус суманд зохион байгуулсугай.

2.2026 оны чөлөөт бөхийн өсвөр үеийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч	Д.Шижирмөнх	Засаг даргын орлогч
Гишүүдэд	Э.Ононцэцэг	Санхүү албаны дарга
	Г.Мөнхгэрэл	ИТХ-ын ажилтан
	Г.Ариунзул	ЭМТ-ийн эрхлэгч
	Х.Ууганцэцэг	ЕБС-ийн захирал
	Ө.Алтанзул	Цэцэрлэгийн эрхлэгч
	А.Амарзаяа	Номын санч
	Х.Амарбаясгалан	Баян-Өлзийт багийн засаг дарга
	А.Уранчимэг	Ангирт багийн засаг дарга
	Э.Бат-Орших	Онон багийн засаг дарга
	Г.Оюунчимэг	Жаргалант багийн Засаг дарга
	Э.Батдаваа	Тархвар зүйч
	Г.Баатархуяг	байгаль хамгаалагч
	Ц.Жинжиймаа	ЕБС-ийн нийгмийн ажилтан
	Г.Мягмарцогт	Хэвлэл мэдээллийн ажилтан
Нарийн бичгийн дарга	Б.Сумъяа	Төрийн сангийн мэргэжилтэн

2.Аймгийн аварга шалгаруулах тэмцээний бэлтгэл ажлыг сайтар хангаж, төлөвлөгөө гарган батлуулж, өндөр түвшинд зохион байгуулахыг ажлын хэсэг (Д.Шижирмөнх)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө ДАВААЖАРГАЛ